



## “ГОВИЙН ӨНДӨР” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 13-ний өдөр

№ 2

Улаанбаатар хот

### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59.4, 60-р зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”-ыг тус тус үндэслэн “Говийн Өндөр”ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээс ирүүлсэн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Говийн Өндөр” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2020 оны 04 сарын 23-ны өдрийн 15 цагт Улаанбаатар хот, Сүхбаатаар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр 601 тоотод хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
  - a. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах;
  - b. 2019 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлтийг батлах;
  - c. Компанийн 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах;
  - d. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг батлах
  - e. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох;
  - f. Их хэмжээний хэлцэл хийхийг зөвшөөрөх
  - g. ТУЗ-с гаргасан ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг танилцуулах;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг “Хурал хуралдуулах тухай зар”-ыг нийтэд мэдээлсэн өдрөөс хойш 19 дэх өдөр буюу 2020 оны 04 сарын 06-ны өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээллэх өдрийг ТУЗ-ийн шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2020 оны 03 сарын 18-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын сонингоор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2020 оны 04 сарын 02-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-р

баталсугай. Хавсралт №3-д заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 09<sup>00</sup>-17<sup>00</sup> цагийн хооронд “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв оффис болон компанийн өөрийн байран дээр ирж танилцах боломжтой.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2020 оны 04 сарын 23-ны 15:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар П.Эрдэнэцэцэг, хурал зохион байгуулах комиссийн даргаар П.Батбаяр, гишүүнээр Ш.Долгормаа, тооллогын комиссын даргаар Д.Шүрэнцэцэг, гишүүнээр Н.Өнөрбаян нарыг тус тус томилсугай.
10. Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаас гарсан шийдвэрүүдийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулсугай.
11. ХЭХ зохион байгуулах асуудлыг Гүйцэтгэх захирал П.Батбаярт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



П.ЭРДЭНЭЦЭЦЭГ /